

МОНГОЛЫН ТЕЛЕВИЗҮҮДИЙН ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН  
ЗАРИМ АСУУДАЛД

Л.Ариун\*

\* ХИС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.)

**Түлхүүр үг:** олон улсын сэтгүүл зүй, Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, мэдээллийн сонголт, мэдээллийн эх сурвалж, мэдээллийн бүтэц.

Ө нөөдөр Улаанбаатарын хэмжээнд 20-иод телевиз үйл ажиллагаа явуулж байна. Үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ явуулдаг ганц телевиз нь олон нийтийн статустай бол бусад нь арилжааны чиглэлээр ажилладаг. Нэвтрүүлгийн чанар, чансаа, техникийн хүчин чадал, сэтгүүлч боловсон хүчний нь чадвар харилцан адилгүй өөр өөр. Гэвч энэ бүхний тухай бус, эдгээр телевиз олон улсын мэдээллийг ямар төвшинд, хэрхэн яаж хүргэж буйг, цаашид юуг анхаарвал зохилтойг гаргахаар энэхүү судалгааг хийлээ.

Олон улсын сэтгүүл зүйн орон зайд мэдээллийн сонголт, ач холбогдол, үнэлэмжийн асуудал нь үндэсний эрх ашиг, эдийн засаг, улс төрийн нөлөө, сонирхол, газар зүйн хамаарал гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлогддог<sup>1</sup>. Энэ үндсэн шалгуур үзүүлэлтээр олон улсын байдлыг мэдээлэх нь манай сэтгүүл зүйн өмнө тавигдаад байгаа шаардлага билээ. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Олон улсын харилцааны бусад үндсэн асуудлуудын хүрээнд мэдээлэх асуудал учир дутагдалтай байгааг судлаачид онцолж байна. Доктор Б.Болд-Эрдэнэ манай олон улсын сэтгүүл зүйг "...Өсөн нэмэгдэж, өргөжин тэлж буй үндэсний эрх ашиг, гадаад бодлогын салшгүй нэгэн хэсэг тогтолцоо төдийгүй, дэлхийн нийгмийг харах монгол цонх болон төлөвших цаг нэгэнт болжээ"<sup>2</sup> гэж дүгнэсэн бол доктор Л.Норовсүрэн "Олон улсын харилцаанд гарч байгаа шинэ хандлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хамгийн түрүүнд мэдэрч, үйл явдлын өрнөлтийг үндэсний эрх ашгийн үүднээс харж үнэлэлт дүгнэлт хийж байх шаардлагатай юм"<sup>3</sup> хэмээн тэмдэглэжээ.

Судлаач, эрдэмтдийн дэвшүүлж буй дээрх шаардлагад үндэслэн өнөөдрийн манай ХМХ-үүд, тэр дундаа телевизийн гадаад мэдээ, мэдээлэл ямар төвшинд байгааг тодорхойлохоор МҮОНТВ, С1, TV-5 телевизийн 14 хоногийн олон улсын мэдээлэлд ажиглалт судалгааг хийлээ.

МҮОНТВ өдөрт 30 минут долоо хоногт 240 минутын гадаад мэдээ, мэдээлэл бэлтгэж цацдаг. Үүнд МҮОНТВ-ийн 11.00, 13.00, 15.00, 18.00, 20.00, 23.00 цагаас явах мэдээллийн хөтөлбөр болгонд ордог гадаад мэдээ, "Гэрэлтэй цонх" хөтөлбөрийн 5 хором булангийн мэдээ, мэдээлэл, сэтгүүлч Б.Оюунчимэгийн бэлтгэн хүргэдэг "Бизнес нь юс" хөтөлбөр багтаж байгаа юм. 14 хоногт 20 минутаар нэг удаа нэвтэрдэг "Бизнес нь юс" нэвтрүүлэг нь олон улсын бизнес, эдийн засгийн байдлыг тойм хэлбэрээр өгдөг манай телевизүүдэд цөөхөн байдаг чамбай нэвтрүүлэгийн нэг юм.

TV-5 телевиз нь өдөрт 50 минут, 7 хоногт 350 минутын гадаад мэдээ бэлтгэж хүргэдэг. Тус телевизийн гадаад мэдээ нь бусад телевизүүдээс харьцангуй их хугацаатай байдаг. Энэ ч үүднээсээ мэдээллийн багтаамж ихтэй. "Интернет мэдээ" нэртэй гадаад мэдээллийн хэсэг нь мэдээллийг харьцангуй задлан шинжилсэн өнгө аястай өгдгөөрөө онцлогтой ч мэдээллийн сонголтын тал дээр учир дутагдалтай ажилладаг. Өөрөөр хэлбэл монгол

үзэгчдэд төдийлөн ач холбогдолтой биш улс орны дотоод амьдралын тухай өгүүлсэн мэдээллийг дэлгэрэнгүй өгөх зэрэг дутагдал гардаг.

С1 телевиз нь хоногт 20 минут, долоо хоногт нийт 170 минутын олон улсын мэдээлэл бэлтгэж цацдаг. Ням гаригт тусгайлсан тойм хөтөлбөр бэлтгэдэг. Мөн хааяа дэлхий дахинд болсон чухал үйл явдлаар шуурхай мэдээ бэлтгэдэг. Тус телевизийн олон улсын мэдээллийн эх сурвалж нь үндсэндээ Ройтерс агентлагаас мэдээ, мэдээлэл авдаг. Мэдээллийн нэг багцад төрөлжсөн сэдэвчилсэн мэдээлүүд, эсвэл нэг газар оронд болж байгаа үйл явдлууд, эсвэл нэг агуулгатай мэдээллүүдийг багцлан хүргэдэг. Тус телевиз нь үзэгчийн сэтгэл зүйд сөрөг сэтгэгдэл үлдээхгүйн тулд муу, муухай, хүнд хэцүү үйл явдлын тухай үзүүлсэн бол төгсгөлд нь гэрэл гээтэй сайн сайхан, сонирхолтой хөнгөн мэдээллийг өгөх бодлого баримтладаг тухай гадаад мэдээллийн алба дурдсан.


**С**удалгаа хийж үзэхэд дээрх телевизүүдийн нийт эфирийн цагийн дунджаар гурав орчим хувийг гадаад мэдээ, мэдээлэл эзэлж байна.

Мөн гадаад мэдээлэл нь зөвхөн мэдээллийн хөтөлбөрт багтдаг мэдээ байгаа нь учир дутагдалтай юм. Телевизүүдийн гадаад мэдээллийг бичлэгийн төрөл зүйлийн үүднээс ангилж авч үзвэл мэдээ, тойм гэсэн мэдээллийн

төрөлд багтдаг хоёрхон зүйлд хуваагдаж байгаа бөгөөд түүний 90 гаруй хувийг нь мэдээ эзэлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл дэлхий нийтийн тулгамдсан томоохон асуудлаар тойм тайлбар хийж задлан шинжилсэн, хэтийн төлөвийг тодорхойлсон, дүн шинжилгээ хийсэн даацтайхан төрөл

зүйлээр хийсэн нэвтрүүлэг байхгүй байгаа нь нийт нэвтрүүлгийн цагтай харьцуулахад ийм бага хувьтай гарахад хүргэж буй шалтгаан болж байна. Энэ нь мөн үзэгчдэд үзүүлэх үр нөлөө, ач холбогдолын хувьд тааруухан юм.



Эх сурвалжийн хувьд сонины гадаад мэдээлэлтэй харьцуулахад телевиз нь олон эх сурвалж ашигладаг, ашигласан эх сурвалж нь үзэгчдэд ил тод байдаг зэрэг давуу талтай. С1 телевиз нь хууль ёсны гэрээгээр, баталгаатай эх сурвалжаас, техникийн өндөр төвшинд мэдээлэл хүлээн авч үзэгчдэд хүргэдэг нь тус телевизийн гадаад мэдээллийн онцлог, давуу тал хэдий ч тухайн улсад хандаж буй олон улсын байр суурь, олон талын өнцгөөс үйл явдлыг харж үнэлж дүгнэх зэрэг нь учир дутагдалтай мэт санагдаж байгаа юм. С1 телевиз зөвхөн Ройтерс агентлагаас мэдээ, мэдээллээ авдаг бол

МҮОНТВ, TV-5 телевиз ВВС, ННК, CCTV, DW гэх мэт дэлхийн томоохон мэдээллийн телевизүүдээс гадна Оросын ОРТ, РТР болон интернет гэх мэт олон эх сурвалжаас авч байна.

Хэдийгээр дэлхийн томоохон мэдээллийн агентлаг, телевизүүд, интернет зэрэг олон эх сурвалж ашиглаж мэдээ, мэдээллээ бэлтгэж байгаа ч манай телевизүүдийн өөрийн сурвалжлагчийг гадаадад суулгадаггүй, хөндлөнгийн эх сурвалжаас авснаар мэдээлэл өрөөсгөл, ач холбогдолгүй байх явдал олонтаа гарч байна. Доктор Ч.Чойсамбын 1997 онд хийсэн судалгаагаар "Монгол телевизийн "Цагийн

хүрд" нэвтрүүлгийн гадаад мэдээллийн 5 хувийг өөрсдөө, 86 хувийг CNN-ээс, үлдсэн 9 хувийг OPT, NHK телевизээс авчээ" гэж гарсан бол өдгөө 10 гаруй жил өнгөрсөн байхад гадны эх сурвалжаас голлон мэдээ, мэдээллээ бэлтгэдэг арга барил манай телевизүүдэд байсаар байна. Харин дээрх судалгаатай харьцуулахад харьцангуй олон эх сурвалж ашигладаг болсон байна гэж үзэж болох юм.

Манай олон улсын мэдээллийн үнэлэмжийн хувьд үндэсний эрх ашиг

тэргүүн зэрэгт тавигдах шалгуур болдог.

Монголын олон улсын сэтгүүл зүйн ач холбогдлын хүрээ нь хамгийн эхэнд хоёр хөршийн, дараа нь эдийн засгийн нөлөө дэмжлэг үзүүлдэг улс орны, дэлхий нийгмийн тулгамдсан, зөрчилт асуудал хэмээн доктор Б.Болд-Эрдэнэ ангилсан байдагтай бид санал нийлж байгаа юм. Энэ ангиллын үүднээс дээрх телевизүүдийн гадаад мэдээг үзвэл:




Дээрх графикаас харвал МҮОНТВ-ийн гадаад мэдээллийн чухал агуулга, онцгой объектыг тусгах ёстой дэс дарааллын дагуу тусгаж Монгол орон, монголчуудыг эрх ашиг сонирхолд нөлөө бүхий хүчин зүйлүүдийг зөв харж мэдээлж чадаж байна гэж үзэж болох юм. Гэвч мэдээллийн дотоод агуулга, сэдвийн хувьд аваад үзвэл тухайн орнуудын дотоодын үйл явдал, сонин

хачин, дуулиан шуугиан зэрэг монгол үзэгчдэд төдийлөн ач холбогдолгүй мэдээлэл байгааг дурдах зүйтэй юм. Хэдийгээр ийм ч бусад телевизүүдтэй харьцуулахад МҮОНТВ нь мэдээллийн үнэлэмжийн үүднээс авч үзвэл хэлбэрийн хувьд ч зөв байгаа нь сайшаалтай юм. Судалгаанд хамрагдсан бусад телевизүүдийн гадаад мэдээллийг мэдээллийн үнэлэмжийн

төвшингээр авч үзэхэд ихэнх хувийг нь ач холбогдол багатай дэлхийн сонин

хачин үйл явдлуудын тухай байгаа нь харагдаж байна.



Бичлэгийн онцлог, ур чадварын хувь телевизүүдийн гадаад мэдээнд дараах нийтлэг шинж ажиглаж байна. Дотоод мэдээлэлтэй харьцуулахад

- Үнэн бодит,
- Мэдээлэл нь товч тодорхой,
- Сонирхолтой, оновчтой дүрс бүхий,

• Аль нэг талыг бариагүй, мэдээллийн тэнцвэрийг баримтласан (С1 телевиз ганцхан эх сурвалжаас авдаг учраас нэг өнцөгөөс харсан байх талтай),

• Шуурхай зэрэг сэтгүүл зүйн шаардлагад тэнцсэн давуу талууд ажиглагдаж байгаа юм. Мэдээллийн бүтцийн хувьд лид, синхрон гэсэн үндсэн хоёр элементээс бүрдэж түүндээ бүрэн дүүрэн мэдээлэл өгч чадаж байгаа нь товч тодорхой байх шаардлагад нийцэж байгаа юм.

## Дүгнэлт

Манай телевизүүдэд олон улсын мэдээллийг үндэсний эрх ашиг, аюулгүй байдал, тусгаар тогтнол, үр ашигтай хамтын ажиллагааны үнэлэмж шалгуураар шүүн мэдээлэх үүрэг үгүйлэгдсээр байна. Энэ нь манай сэтгүүл зүйд олон улсын мэдээллийг мэдээлэх тогтсон зөв уламжлал байхгүйн дээр энэ чиглэлээр мэргэшин гүнзгийрсэн боловсон хүчин дутмаг байгаатай холбоотой юм. Тэрчлэн манай ХМХ-үүд телевизийн гадаад мэдээлэлдээ анхаарал муу хандуулж байгаа ба гадаад мэдээний редактор, сэтгүүлчээр орчуулагчийн мэргэжилтэй хүмүүс голлон ажилуулдаг нь учир дутагдалтай юм.

Манай телевизүүдийн бэлтгэж буй гадаад мэдээлэл Монгол улсын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын

үзэл баримтлалтай нийцэж, нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлагыг харгалзахгүй байдал ажиглагдаж байна. Энэ нь гадаад мэдээлэл бэлтгэдэг боловсон хүчний мэдлэг ур чадвартай холбоотойгоос гадна гадаадад суух сурвалжлагч байхгүйтэй холбоотой. Хөрш орнуудад төдийгүй, АНУ, Япон зэрэг дэлхийн томоохон орнуудад байнгын сурвалжлагч суулгаж, тэдгээр орны дотоод амьдрал, эдийн засгийн хөгжил, түүнээс Монголд үзүүлж болох эерэг, сөрөг нөлөө зэргийг тасралтгүй үзүүлж байх шаардлага байна.

**М**эдээллийн төрөл зүйлийн хувьд шуурхай товч байх гол шаардлагад нийцэж байх ч нөгөө талаас дэлхий дахинд болж буй үйл явдлыг тоймлож, хэтийн төлөвийг тодорхойлж бичсэн даацтай нийтлэл нэвтрүүлэг манай ХМХ-д үгүйлэгдсээр байна.

Телевизүүдийн олон улсын мэдээллийн дээрх тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэхийн тулд юуны өмнө сэтгүүлч боловсон хүчин бэлтгэж буй сургуулиуд эдийн засаг, нийгэм улс төр, олон улсын харилцааны талаар өндөр мэдлэгтэй, хэлний боловсрол сайтай боловсон хүчин бэлтгэх, цаашлаад томоохон ХМХ-үүд хөрш хоёр орон болон дэлхийн томоохон орнуудад өөрийн сурвалжлагчийн суулгаж, Монгол орон, монголчуудын эрх ашгийн үүднээс харсан, үйл явдлыг улс төрийн, нийгэм-эдийн засгийн

хүрээнд нь задлан шинжилсэн нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж байх шаардлага зүй ёсоор гарч байна. Дээрх үндсэн асуудлуудыг шийдвэрлэсэнээр ХМХ-үүд гадаад мэдээлэлд ач холбогдол өгөхгүй байх, зай талбайгаа хомсхон зориулах, дан ганц мэдээлсэн маягаар дамжуулагчийн байр сууринаас хандах зэрэг бусад асуудлууд шийдвэрлэгдэх боломжтой.

### Ишлэл

<sup>1</sup> Болд – Эрдэнэ Б. 2005. Шинэ цаг үе, шинэ хандлага, шинэ сэтгүүл зүй. “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №249, 20 дахь тал.

<sup>2</sup> Мөн тэнд, 24 дэх тал.

<sup>3</sup> Норовсүрэн Л. Олон улсын мэдээлэл дэх геополитикийн зарим асуудал. “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №249, 135-р тал.

<sup>4</sup> Чойсамба Ч. 1997. Монгол телевизийн “Цагийн хүрд” нэвтрүүлгийг ОРТ-ийн “Время”-тай харьцуулах нь // Радио телевизийн мэдээллийн хэл найруулга (эмхтгэл). УБ. 17 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд – Эрдэнэ Б. 2005. Шинэ цаг үе, шинэ хандлага, шинэ сэтгүүл зүй. “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №249.

2. Норовсүрэн Л. Олон улсын мэдээлэл дэх геополитикийн зарим асуудал. “Сэтгүүл зүй” МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №249.

3. Чойсамба Ч. 1997. Монгол телевизийн “Цагийн хүрд” нэвтрүүлгийг ОРТ-ийн “Время”-тай харьцуулах нь // Радио телевизийн мэдээллийн хэл найруулга (эмхтгэл). УБ.

4. Мөнчөр М. 2005. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ.

5. Эрдэнэ Ч. 1992. Мэдээний машин. УБ.

6. Полетаев Э. 2004. Международная журналистика. Алтаты.

## Resume

There isn't rule to report international news in Mongolian media press. There fore translators work in the media press unisist of international journalists. It means that Mongolian media press doesn't pay attention

for it and educated international journalists haven't been prepared yet in Mongolia. It's good to report news in brief. However it's lack of writing about international events in Mongolian media press. It means that it can't give chance for people to discuss and make decisions.